

“УВДИСЫН ДАЛАЙ” БҮТЭЭЛ ДЭХ  
НОТОЛГООНД СУУРИЛСАН ЖОРЫГ ШИНЖЛЭХҮЙ

Г.Энхжин<sup>1</sup>, Б.Гэрэлмаа<sup>2</sup>, С.Цэцэгмаа<sup>3</sup>, Ш.Болд<sup>4</sup>

<sup>1</sup>ЭЗШУИС-ийн УАУ-ны Сургууль, <sup>2</sup>Долмалин эмнэлэг

<sup>3</sup>Эм судлалын хүрээлэн

<sup>4</sup>Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

ANALYZING A EVIDENCE-BASED PRESCRIPTION IN THE  
“MAN NGAG RIN CHEN ‘BYUNG”

Enkhjin G<sup>1</sup>, Gerelmaa B<sup>2</sup>, Tsetsegmaa.S<sup>3</sup>, Bold.Sh<sup>4</sup>

<sup>1</sup> Traditional medicine research department of MUPS

<sup>2</sup>Dolmalin Hospital, <sup>3</sup>Institute of Pharmacology,

<sup>4</sup>Traditional Medical Research Institute

### Abstract

The basis of the development of traditional medicine in the XXI century is to study the old medical books and scriptures created by ancient Mongolian doctors and scientists of previous generations. For example, it is important to deepen the scientific understanding of “Man ngag rin chen ‘byung” written by Mongolian doctor ‘Jam dpal chos kyi bstan ‘dzin phrin las in Tibetan, and to understand the content and charms of the Man ngag rin chen ‘byung.

### Purpose

Sampling and analysis of experimental prescriptions in the “Man ngag rin chen ‘byung” written by Mongolian doctor ‘Jam dpal chos kyi bstan ‘dzin phrin las in Tibetan.

**Research methods:** Methodologies of ancient textbook analysis and check list of textbook were used.

### Conclusion

In the concluding remarks of the “Man ngag rin chen ‘byung” written by Mongolian doctor ‘Jam dpal chos kyi bstan ‘dzin phrin las, it was stated that there are many medicinal raw materials in the practice. He mentioned that: “I have summarized the benefits of medical literature written by the ancient doctors of Mongolian medicine to facilitate for people to learn.” An analysis of this sentence reveals that in the current understanding of medical science, it is evidence-based practice (EBP).

**Keywords:** ancient doctors, “Man ngag rin chen ‘byung”, prescription, medical literature

## Үндэслэл

Түүхийн энэхүү урт хугацаанд анагаах ухааны олон салбар түүний дотроос эм судлал, эм найрлагын судлал нэн эртний уламжлалтай бөгөөд тухайлбал нүүдэлчдийн анхны төр улс Хүннүгийн үеэс дан болон нийлмэл эмийн мэдлэг гүнзгийрэн өдөр тутам хэрэглэдэг “нүүдэлчийн үрэл” эм хэрэглээний өргөн хүрээтэй болж байсны зэрэгцээ Түрэг, Уйгарын үед хөгжлийн тодорхой түвшинд хүрч улмаар XVI зуунаас эхлэн Төвөд анагаах ухаанаар дамжин дэлгэрсэн Энэтхэгийн Аюрведийн анагаах ухааны вата, питта, кафа-хий, шар, бадган, сапта дхатус-долоон тамир, три мала-гурван хирийн онолд суурилан хөгжлийн шинэ шатанд оржээ<sup>1,2</sup>.

Нэн ялангуяа XXI зууны уламжлалт анагаах ухааны хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, эрдэмтдийн бүтээн туурвисан анагаах ухааны хуучин ном, судрыг уншиж судлах, уг номонд байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамба нарын гарын авлага, увдисын гүн утгыг онож ойлгох нь чухал байна.

## Судалгааны ажлын зорилго

Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын далай” эмийн сударт дахь туршлагат жоруудыг түүвэрлэн дүн шинжилгээ хийх.

## Судалгааны арга зүй

### 1. Эх бичиг, сурвалж бичгийн судлалын арга

Бид судалгаанд ашигласан материалаа ажлынхаа зорилго, зорилтуудад нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацааг хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлж, намтар, түүхийн судалгааг хийн улмаар бүтээлийн гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгаах үзлээ.

Мөн зохиолын дотор агуулагдах эм судлалын шинжлэх ухаантай шууд холбоотой мэдээ, сурвалжийг сонгон авч цаг хугацааны дараалалд оруулан бусад бүтээлийн мэдээллээр баяжуулан оюун дүгнэлт хийв.

### 2. Магадлан жагсаах арга

Бид уг аргаар “Увдисын далай” судрын доторх эмийн түүхий эд болон, ёгт нэрийг түүвэрлэн жагсааж орчуулга, тайлбар хийх урьдчилсан нөхцлийг бүрдүүлэхэд ашиглав. Түүнчлэн уламжлалт эмийн түүхий эд болон жорын мэдээллийн сан бүрдүүлэх үндэс болгосон.

## Судалгааны үр дүн

1. Эмчилгээний бодит байдлыг үндэслэн улируулан хэрэглэх ба нэмэр тавьж хэрэглэсэн жишээ 330 байна<sup>1</sup>. Тухайлбал: гүргэм, жуган, лиш, удвал дөрвийг гол эм болгож, зүрхэнд бууж сарнисан бол цагаан зандан, задь, зүрхэн шош гурвыг нэмж, амин судалд алдагдсан бол хар агар, рүда, гүргэм гурвыг нэмж, уушгинд буусан бол цагаан сороол, үзэм, чихэр өвс гурвыг нэмж, элгэнд буусан бол төмрийн талх, арүр, башига, барагшин дөрвийг нэмж, ходоодонд буусан бол анар, мана, библин гурвыг нэмж, дэлүүнд буусан бол алтан цэцгийн үр, үнсэн давс, гагол гурвыг нэмж, гэдэс олгойд буусан бол өмхий давс, шимэлдэг, мариныг нэмж, бөөрөнд буусан бол заар, сүгмэл, эр замба гурвыг нэмж өгөх зэргээр тоо нь олширно.
2. Тан эмийг ганцаар хэрэглэсэн жишээ 307 зүйл байна. Жишээлбэл: сармисыг шүдэнд зуулгах, агийн навчыг нүдээд шүүсийг нь чихэнд дусаах, зааны гиваныг чанаж уулгах гэх мэт.
3. Тан эмийг идээ ундаатай хавсарч хэрэглэсэн жишээ 184 зүйл байна. Жишээлбэл: хуажуу, бурам хоёрыг

талхдаж архинд зуурч хамарт дусаах, ёлын хоолойг буудайн архинд дэвтээж өгөх, библингийн талхыг тостой найруулж түрхэх гэх мэт.

4. Тан эмийг бусад түүхий эдтэй хавсарч хэрэглэсэн жишээ 32 зүйл байна. Жишээлбэл: өөрийнх нь шээсэнд рудаг нарийн дэвтээгээд нүдэнд тавих, хүчин төгөлдөр шатаасан гавалын нүүрсийг талхдаж өөрийн шээсэнд зуурч түрхэх, цэх галуун тавагийг нягт талхдаж үнээний шээсэнд зуураж түрхэх гэх мэтээр улируулж хэрэглэсэн эм, тан эм, тан эмийг идээ ундаантай, тан эмийг бусад эмийн түүхий эдтэй хавсарч хэрэглэсэн жишээ нийт 853 зүйл байна. Хэрэв эдгээрийг эмийн найрлага гэж тоолж 2528 жор дээр нэмбэл нийт 3381 жор болно<sup>4,5</sup>.


Тэрбээр номондоо оруулсан жоруудаа хэрхэн сонгон авсаныг задлан үзвэл:

1. Зарим жоруудын олон түмнээс цуглуулж, уг жороос чухал хэрэгцээтэйг нь түүн ашигласан.
2. Өөрийн эмчилгээний туршлагын явцад үйлдэл нь нэн сайн чухал жоруудыг авсан буюу заримыг өөрөө хувилган хэрэглэсэн жоруудаа оруулсан байна.


Өргөн хэрэглэгддэг чухал эмийн найрлагуудад шимийн далай, оньч цагаан найралт, зүрхний найралт, гавар-18, Дармогийн их шарын найралт, жоншийн халуун, хүйтэн найралт, төмрийн талх-18 зэргийг дурдаж болно. Үүнээс гадна тухайн үедээ нэр хүндтэй байсан олон ном, зохиолыг ултай судалж, тэдгээрийн доторх жорыг өөрийн бүтээлдээ тусгажээ.

Жишээлбэл: шүн агар-8, гүргэм-13, сэмбэрүү-4, үзэм-7, мана-4, гурван үрийн тан, сэрдог-5, гарнаг-10, гоюу-13-ыг дурдах байна.

Мөн эмчилгээнийхээ туршлагын явцад өөрийн шинээр найруулан гаргасан дэгд-25, яжим-25, гүргэм-16, наран, сарны найралгыг бүтээлдээ оруулжээ (Pic 1,2).



Pic 1. Classification of treatment experiences  
**Explanation:** 1. Medicine-76, 2. External therapy-24, Religious ceremony-5



Pic 2. Classification of experimental prescription type  
**Explanation:** 1. Decoction-8, 2. Powder-33, 3. Pills-10, 4. Others-13, 5. External medicine-12

Эдгээр эмээс гадна зарим өвчнүүд тухайлбал нүдний өвчнийг эмчлэх талаар онол, арга зүйн шинэ хандлагыг бий болгосон нь ихээхэн сонирхол татдаг. Нүдний өвчнийг маш нарийн ялгаж 94 зүйлээр хуваан авч үзжээ.

Түүнчлэн уушгины дагшуур, бадганаар залгиур хаагдах өвчин, нүдэн яр зэрэг өвчний талаар тодорхой бичсэн байдаг<sup>6</sup>.

Уг зохиолд байгаа өөр нэг онцлог нь эртний зохиолыг дэлгэрүүлсэн буюу баяжуулсан тэмдэглэл нилээд бий. Жишээ нь: Хий өвчнийг анагаах их, дунд, бага шимийн хураангуй, доод хий хуйларсныг туулгаар буулгах ба эм найруулах арга, эм өгөх ёс, бурууг дарах, сүүлийг нь таслах, тус эрдэм зэрэг 5 зүйлээр өгүүлж, ясны шөлөөр ташуурдах, тас, ёл, янгир, хөх ямаа, мангис (дорго) зэрэг амьтдын цусаар хүлэглүүлж өгөх, боловсорсон ба дэлгэрсэн халуун хоёрыг ялгаатайгаар өгүүлснээс гадна нян өвчнийг 31 зүйлээр дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна.

Нян хижиг өвчнийг ингэж нарийн ангилж, эмчлэх аргыг нь шийдэхээс гадна эмчилгээний шинэ шинэ арга, жорыг олноор нь нэмж Монгол анагаах ухааны онол, эмчилгээний практик хэрэглээг ихээхэн баяжуулжээ.

Тухайлбал:

Бахуу өвчинд далайн ногоо (далайн байцаа), гүүний цэгээ (саам) хэрэглэхийг өгүүлж эмийн талаар цагаан лууван бол 100 амт төгөлдөр, 100 өвчнийг засч, нян өвчинд үүнээс дээд сайн эм үгүй гэх зэрэг баялаг агуулгыг багтаажээ.

Миндол Жамбал зохиолынхоо төгсгөлд: “Анагаах үйлдэх ерөндөгийн зүйл арвин байдаг. Би хүмүүсийн сурч эзэмшихэд дөхөм болгохын тулд монгол эмнэлгийн эртний мэргэд нарын зохиосон гол, их судар зохиолын шимийг хураангуйлан товчлон өгүүлсэн нь энэ билээ” гэж ном бичсэн зорилгоо тодорхойлсон байдаг<sup>7</sup>.

Үүнээс үндэслэн Миндол Жамбал бол Монголын уламжлалт анагаах ухааны эм, найрлагын судлалын хөгжлийн бүтэн

алхамаар урагшлуулахад чухал нөлөө үзүүсэнээр барахгүй дорно дахины анагаах ухааны хөгжилд дорвитой түлхэц үзүүлэхүйц том бүтээлийг монгол хүн өөрийн оюуны цар, хэмжээгээр бүтээн туурвиж чаддаг юм гэдгийг харуулж өгсөн гавьяатай эрдэмтэн байжээ хэмээн дүгнэж байна<sup>8</sup>.

Хожим нь Жамбалзундуй зэрэг эрдэмтэд “Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарах орон оршвой” зохиолыг тайлбарлаж “Хувилгаан түлхүүр”, “Эрдэнийн түлхүүр”, “Далд утгын түлхүүр”, “Онъсон утгын түлхүүр” зэрэг дөрвөн боть тайлбар зохиолыг бичжээ. Дээрх дөрвөн номыг “Увдисын далайн дөрвөн түлхүүр” буюу “Дөрвөн дэмиг” гэдэг.

### Дүгнэлт

Монголчуудын өвөг дээдэс, нүүдэлчид түүхэн урт хугацааны турш өвчин, эмгэгтэй тэмцэх, эрүүл амьдрах ухааныг хөгжүүлэх явцдаа газар нутгийн онцлог, байгаль, цаг уурын эрс тэс байдал, аж амьдралын өвөрмөц нөхцөл, бие махбодын онцлогтойгоо тохирсон эм судлал, эм найрлагын салбар ухааныг бий болгожээ. Аажимдаа энэхүү ухаан нь монголчуудын сэтгэлгээний цар хүрээ, танин мэдэхүйн хөгжил, дэвшлийн нөлөөгөөр агуулга, онол, өвөрмөц нэр томъёо бүхий мэдлэг ухааны цогц ойлголтыг бий болгож улмаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэж улам баяжуулан хөгжүүлсээр том, жижиг олон арван ном судрыг орчуулахын зэрэгцээ өөрийн газрын хуваарьт тохируулан шинээр баяжуулан бичиж ирсэн байна.

Түүний номын төгсгөлийн үгэндээ илэрхийлсэн “Анагаах үйлдэх ерөндөгийн зүйл арвин байдаг. Би хүмүүсийг сурч эзэмшихэд дөхөм болгохын тулд монгол эмнэлгийн эртний мэргэд нарын зохиосон гол, их судар зохиолын шимийг хураангуйлан

товчлон өгүүлсэн нь энэ билээ” гэсэн бичвэрийг задлан шинжилж, нарийвчлан үзвээс өнөөгийн анагаахын шинжлэх ухааны ойлголтоор бол evidence-based practice (EBP) буюу нотолгоо түшсэн практик болох нь илт харагдаж байна.

#### Ном зүй:

1. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. 4 боть, УБ, 2013
2. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. 2 дугаар боть, УБ, 2013
3. “Монгол эмнэлгийн увдисын далай”-ан судалгаа. (Бо Хасан, Наранцогт эрхлэн найруулав), ӨМХБ, ӨМ-ын ШУТМХХ, 2015, 774 х.
4. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарах орон оршвой. хэмжээ: 850x1168 мм, Үндэсний хэвлэлийн хороо, анхдугаар хэвлэл, Хятад, 2007, 648 х.
5. མན་ངག་ལེན་ཆེན་འབྲུང་གནས་ “Увдисын далай” төвөд эхтэй нь тулган кирилл үсгэнд буулгасан гар бичмэл. (Ш.Болд, Г.Энхжин, Х.Улаан-Од, Т.Ариунжаргал, Б.Болор), 2016
6. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарах орон оршвой. хэмжээ: 850x1168 мм, Үндэсний хэвлэлийн хороо, анхдугаар хэвлэл, Хятад, 2007, 648 х.
7. “Монгол эмнэлгийн увдисын далай”-ан судалгаа. (Бо Хасан, Наранцогт эрхлэн найруулав), ӨМХБ, ӨМ-ын ШУТМХХ, 2015, 774 х.
8. Анагаах ухааны шашдир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарах орон оршвой. хэмжээ: 850x1168 мм, Үндэсний хэвлэлийн хороо, анхдугаар хэвлэл, Хятад, 2007, 648 х.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:  
ЭЗУ-ы доктор, дэд профессор  
Б.Цэрэндолгор